МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 02 өдөр Дугаар А/417 Номгон

Баян-Өндөр, Бөмбөгөр, Эрдэнэцогт, Галуут
Хүрээмарал сумын батлан хамгаалах чиглэлийн
үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, "Цэргийн албаны тухай" хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах" журмын 4 дүгээр зүйлийн 4.1.8, 9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түүхэн 100 жилийн ой нь тохиож байгаа Баян-Өндөр, Бөмбөгөр, Эрдэнэцогт, Галуут, Хүрээмарал сумын батлан хамгаалах чиглэлийн үйл ажиллагаанд үзүүлэх зардлыг баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 9,000,000 (Есөн сая) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс зарцуулахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т үүрэг болгосугай

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

842311077